



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.08.06 № 461
танай -ны № -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох "Иргэдийн оролцооны нэгдэл" намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

"Иргэдийн оролцооны нэгдэл" намын Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Иргэдийн оролцооны нэгдэл" намын мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Иргэдийн оролцооны нэгдэл намын танхимд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Ц.ӨСӨХБАЯР

**ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Хүний эрх, хувийн хэвшил, тогтвортой хөгжил, иргэний оролцоог эрхэм болгодог баруун төвийн намын хувьд Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН) "боловсрол, бизнесийн орчин, тогтвортой хөгжил" гэсэн гурван голлох чиглэлээр улс орныхоо хөгжилд дэвшилтэт өөрчлөлтийг авчрах зорилт тавин мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж байна. Үүнд:

Нэг: Боловсролын чиглэлээр

Боловсрол бол Монгол улсын өнөөдөр болон ирээдүйн гол хөрөнгө оруулалт юм хэмээн ИОНН үзэж буй тул "Ойрхон сургууль" хөтөлбөрийг онцгой анхаарч ажиллана. Энэхүү хөтөлбөр нь бага дунд болон насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагч нарын хөдөлмөр, бизнес эрхлэх боломжийг хангах, хүн амын суурь эрүүл мэндийн асуудлыг багасгах, хот байгуулалт, нийтийн тээврийн тулгамдсан асуудлыг эергээр шийдвэрлэх, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд өсгөж боловсролтой иргэн болгоход гүн гүнзгий нөлөө үзүүлэх болно. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд:

- 1.1. Хүүхэд бүр явганаар болон аливаа тээврийн хэрэглэлээр гэрээс сургууль, сургуулиас гэр хүртэл зорчиход 15 минутаас илүү хугацаа зарцуулахгүй байхаар зохион байгуулалтын өөрчлөлт хийнэ.
- 1.2. Мөрийн хөтөлбөрийн 1.1-д заасан ажлыг хийхэд хамгийн түрүүнд тухайн хорооны хүүхэд байнга оршин суудаг хороондоо бүртгэгдэх журмыг батлуулах ажлыг хуульд нийцүүлэн журамлах ажлыг зохион байгуулна.
- 1.3. Хүүхдийн сурх орчинд сургууль, анги танхим, багш, гэр бүл, сургуулийн эргэн тойрны зай талбай, орчны хөршүүд багтах тул сургуулийн үйл ажиллагааны дүрэм, сургалтын хөтөлбөр зэргийг дээрээс батлахыг халж, харин сургууль дундын сургалтын мэргэжилтэн, тухайн сургуулийн багш, эцэг эх, асран хамгаалагч нар хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хоёр. Бизнесийн орчны чиглэлээр: Шударга татвар- Тэгш орчин

Хувийн хэвшил бол улс орны эдийн засгийн гол хөдөлгөгч хүч гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам үздэг учраас хувийн хэвшилд бизнесийн тэгш боломж, эрүүл өрсөлдөөний орчныг хангах нь бидний гол зорилтын нэг юм. Өнөөгийн бизнесийн орчин нь улс төр маш их холилдсон, цөөн хэдэн компани шударга бус давуу байдлаа ашиглан бусдынхаа бизнесийн орон зайлж хумьсан, бизнес эрүүлээр өсөж өндийх, тэлэх нөхцөл алдагдсанаас үүдэн залуучууд эх орондоо бизнес хийхээс шантарч олноороо гадаад улс руу гарах болсон нь манай орны хөгжлийг хойш татах хэмжээнд хүрлээ гэж ИОНН үзэж байна. Иймээс татвар, төсөв,

өрсөлдөөний бодлогыг доорх байдлаар өөрчилж бизнесийн орчныг сайжруулна.
Үүнд:

- 2.1. Орон нутгаас өгдөг аливаа тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтыг цөөлөх болон шаардлагатай гэж үзвэл зайлшгүй олгох ажлыг хөнгөвчлөх ажлыг зохион байгуулна.
- 2.2. Тухайн хорооны иргэн төрийн худалдан авалтад оролцох мэдээллийн ил тод байдлыг бий болгож, хэрэв хуулиар заасан шаардлагыг хангасан бол тухайн сум, хороо, аймаг, дүүргийн бизнес эрхлэгч давуу эрхтэй оролцох ажлын талаар хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийг санал болгож, журам боловсруулна.

Гурав. Тогтвортой хөгжлийн чиглэлээр

Байгаль орчин, иргэний боловсрол нь тогтвортой хөгжлийн бат суурь гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам үздэг ба дараах бодлогыг иргэдийн идэвхтэй оролцооны тусlamжтайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Хур тунадас багатай, гандуу хуурайгаас үүдэн гамшиг тохиолдох магадлалтай Монгол оронд эзэмшил газар болон бэлчээрийн ногоон бүрхүүлийг нэмэгдүүлэх “Хурын шим” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Усны хүртээмж багатай Монголд орны хувьд иргэд ганцаараа буюу хамтран өөрийн болон дундын эдэлбэр газарт ногоон байгууламж барих түүнийг хувийн хэвшлийн банк санхүүгийн байгууллагаас санхүүжүүлэх үйл ажиллагааг хөхиулэн дэмжсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 3.2. Монгол орны байгаль цаг уур, газар зүйн нөхцөл байдлын онцлогт нийцсэн, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох аливаа үйл ажиллагааг иргэд хувийн хэвшилтэй хамтран шийдэж үр дүн гарч байгаа бол тэдгээр үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зохион байгуулалтын ухаалаг дэмжлэг үзүүлнэ. Нэг удаагийн далайлтаар компанчилах замаар аливаа тогтвортой шийдлийг устгадаг байдлыг таслан зогсоно.
- 3.3. Орчны бохирдлыг багасгахад иргэдийн оролцоотой, тогтвортой шийдлийг дэмжинэ. Иргэд бүтээх, боловсруулах үе шатанд нь оролцоогүй, хэрэглээнд нэвтрэсний дараа иргэдийн хариу үнэлгээнд суурилсан хөгжүүлэлт хийгдээгүй, Монгол орны эрс тэс уур амьсгалд 24 сараас доошгүй хугацаанд туршигдаагүй аливаа технологийг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй ба түүнд Засгийн газрын баталгаа гаргахгүй. Ногоон хөгжилд зориулсан болон орчны бохирдлын эсрэг бүтээгдэхүүн нь эрс тэс уур амьсгал, хэрэглэгчдийн соёлд нийцэх эсэх нь 24 сарын ашиглалтын явцад нотлогдсон бол худалдан авалт, бусад хөнгөлөлтийн дэмжлэгт хамрагдана.
- 3.4. “Иргэдийн оролцоо - Нийтийн Хяналт”-ын соёлыг бүтээн байгуулалтын талбар болон орон нутгийн удирдлагад тавих иргэний хяналтыг хуульчилж нэвтрүүлнэ. Аливаа бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг иргэдийн оролцоогүйгээр шийддэг байдлыг хална.

- 3.5. Аливаа бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эхлэхээс хамгийн багадаа нэг жилийн өмнө үйл ажиллагаанд шууд өртөх иргэдтэй уулзалт, танилцуулга эхлүүлсэн байхыг хуульчилна. Хэрэв иргэдийн 85% нь дэмжвэл төслийг эхлүүлэх зөвшөөрлийг авах ба нөхөн төлбөрийн асуудлыг эрх ашиг нь хөндөгдөж буй талуудтай заавал тохирч, гэрээгээр баталгаажуулсан байхыг шаардана.
- 3.6. Эрх ашиг нь хөндөгдөж буй талд олгох нөхөн төлбөр болон орчны иргэдийн хөдөлгөөний нягтралд орж буй өөрчлөлтийг хэрхэн зохицуулах зэрэг асуудлыг тусгасан гэрээгүйгээр тухайн төслийн үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл өгсөн байвал иргэдтэй зөвшилцөөгүйн улмаас учирсан хор хохирлыг уг ажлыг эхлүүлэхийг зөвшөөрсөн албан тушаалтнаар төлүүлдэг болгоно.
- 3.7. Хэрэв Төрийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар аливаа бүтээн байгуулалт хийж буй бол тухайн бүтээн байгуулалтын байршил сонгох асуудлаар заавал нийтийн сонсгол хийдэг болгоно. Төрийн байгууллагын санаачилгаар уг бүтээн байгуулалтыг хийх бол нээлттэй хэлэлцүүлэг, сонсголын зардлыг тухайн төслийн төсөвт тусгадаг байхаар хуульчилна.
- 3.8. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл нь иргэдэд учрах гамшгийн аюулыг нэмэгдүүлж байвал уг төсөлд зөвшөөрөл өгөхийг хориглоно. Улс, орон нутгийн төсөв, олон улсын болон гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй аливаа төсөл, бүтээн байгуулалт нь тухайн орон нутгийн гамшгаас хамгаалах байнтын, үндсэн бүтцийг эздэх, устгах, гамшгаас хамгаалах чадавхыг сулруулах, эсхүл ийм бүтэц байгуулахаар төлөвлөсөн байршилыг эзлэх, хааж хаших үр дагавартай байгаа бол уг төсөлд зөвшөөрөл олгохыг хориглоно. Хэрэв үүнийг зөрчиж зөвшөөрөл олгосон бол зөвшөөрөл олгосон бүх шатны албан тушаалтан, нийтийн аюулгүй байдлын өмнөөс төслийг хянаж нягтлах мэргэжлийн үүрэг хүлээсэн этээдэд эрүүгийн хариуцлага ногдуулдаг тогтолцоо нэвтрүүлнэ.
- 3.9. Гамшгаас хамгаалах байгууламжийг гэмтээх, өөрчлөх, эvdэх, устгах зөвшөөрөл өгсөн орон нутгийн төрийн захиргааны болон төрийн агентлагийн ажилтан, албан тушаалтныг төрийн албанаас чөлөөлж, дахин төрд ажиллуулах эрхийг хасна.
- 3.10. Иргэний боловсрол, иргэд орчныхоо болон Монгол улсынхаа тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах шийдлийг харилцан зөвшилцэж гаргах үйл ажиллагааг иргэний нийгмээр дамжуулан дэмжинэ.